

ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТЭД 2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.

Булган аймгийн Засаг даргын Тамгын газар нь 2022 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний www.unelgee.gov.mn цахим санд байршуулсан аймгийн Засаг даргад хэрэгжүүлж ажиллахаар үүрэг болгон даалгасан 42 шийдвэрийн 125 заалтыг хяналтад авч холбогдох журмын заалтуудыг баримтлан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн санд хугацаанд нь байршуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэн ажиллалаа.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр хяналтад авсан 42 шийдвэрийн 125 заалтын 114 (91.2%) нь бүрэн хэрэгжсэн, 8 (6.4%) нь хэрэгжих шатанд, 2 (1.6%) хэрэгжилт хангалтгүй, 1 (0.8%) нь хэрэгжилт тооцох хугацаа болоогүй заалт байгаа ба биелэлтийн дүнг дунджаар авч үзвэл **96,9** хувьтай буюу **4.84** оноотой үнэлэгдэв.

Дээрх хүснэгтээс харахад тогтоол шийдвэрийн хэрэгжилт сайн буюу нийт хяналтад авсан шийдвэрүүдийн 91,2 хувь нь бүрэн хэрэгжиж үр дүнд хүрсэн, харин 6.4 хувь нь хэрэгжих шатанд буюу зохион байгуулалтын үйл ажиллагаа хийгдэж байгаа, харин 0.8 хувь нь 2023 оноос үр дүнг тооцож ажиллах шийдвэрийн заалтууд багтаж байна. Хөрөнгийн эх үүсвэр, болон удирдлага зохион байгуулалтаас шалтгаалж 2 заалт хэрэгжилт хангалтгүй байна.

Мөн тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг нарийвчлан авч үзвэл Монгол улсын 8 хуулийн 68 заалт 99.6 хувь, УИХ-ын 2 тогтоолын 2 заалт 65 хувь, УИХ-ын байнгын хорооны 4 тогтоолын 5 заалт 100.0 хувь, Ерөнхийлөгчийн 5 зарлигийн 14 заалт 97,9 хувь, Засгийн газрын 7 тогтоолын 14 заалт 93.6 хувь, Засгийн газрын хуралдааны 8 тэмдэглэлийн 10 заалт 90.0 хувь, Засгийн газрын 4 албан даалгаврын 4 заалт 92.5 хувь, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 4 зөвлөмжийн 8 заалт 96.3 хувьтай тус тус хэрэгжсэн.


2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР ХЭРЭГЖИЛТИЙГ
ТООЦОХ ШИЙДВЭРИЙН ДҮНГ НЭГТГЭХ ХҮСНЭГТ

Булган		Тогтоол, шийдвэр											
		Үүнээс											
		Нийт	Үүнээс										
Нийт	УИХ-ын тогтоол		УИХ-ын байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	Монгол улсын хууль	Засгийн газрын тогтоол	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	Засгийн газрын албан даалгавар	ҮАБЗ-ийн зөвлөмж	Ерөнхий сайдын захирамж	ҮАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл		
Хяналтад авсан нийт		42	42	2	4	5	8	7	8	4	4	0	0
Хяналтад авсан нийт зүйл		125	125	2	5	14	68	14	10	4	8	0	0
Үүнээс	Бүрэн хэрэгжсэн 100 хувь /90-100/	114	114	1	5	13	66	11	8	3	7	0	0
	Хэрэгжих шатанд 70.0 хувь /50-89/	8	8	0	0	1	1	3	1	1	1	0	0
	Хэрэгжилт хангалтгүй 30.0 хувь /10-49/	2	2	1	0	0	0	0	1	0	0	0	0
	Хэрэгжээгүй 0.0 хувь /0-9/	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
	Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй	1	1	0	0	0	1	0	0	0	0	0	0
Биелэлтийн дүн /хувь/		96.9	96.9	65.0	100.0	97.9	99.6	93.6	90.0	92.5	96.3	#DIV/0!	#####

БИЕЛЭЛТИЙГ НЭГТГЭСЭН: ХШУДАХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН...../Б.НАСАНЖАРГАЛ/

ХЯНАСАН: АЗДТГ-ЫН ДАРГА...../Д.АЛТАНШАГАЙ/

Тогтоол, шийдвэрийн хяналтад авсан заалтуудыг аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсүүд хариуцсан салбартаа хэдэн хувийн хэрэгжилттэй зохион байгуулсныг доорх графикаар үзүүлэв.



Үүнээс харахад Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Санхүү, төрийн сангийн хэлтэс, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Нийгмийн бодлогын хэлтсийн, хяналтад авсан шийдвэрүүдийн хэрэгжилт хангагдсан байна. Энэ нь дээрх хэлтсүүдийн хяналтад авсан шийдвэрийн заалтуудын дийлэнх хувь нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуультай холбоотой бөгөөд аймгийн албан ёсны вэб сайтад байршуулах мэдээллүүдийг бүрэн оруулж, мэдээлэл хариуцагч нь хууль хэрэгжүүлэх зохион байгуулалтыг нэлээдгүй сайн хийн, баяжуулалт, шинэчлэлтийн ажил болон үйл ажиллагааны ил тод байдал сайжирсан эерэг үр дүн харагдаж байна. Мөн Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар өрнөж буй “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, Монгол бичгийн хэрэглээ, Эзэн Богд Чингис хааны иш хөргийг хүндэтгэн залах тухай зэрэг шийдвэрүүдийн биелэлтийг хангахаар удирдлага, зохион байгуулалтын авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд үр дүнд хүрч, хэрэгжилт хангагдсан.

2022 оны жилийн эцсийн байдлаар хяналтад авсан шийдвэрүүдийн биелэлт Хууль, эрх зүйн хэлтэс 88.3 хувийн биелэлттэй байгаа нь тухайн салбарт хэрэгжиж буй шийдвэрүүд нь төсөв, санхүү, удирдлага, зохион байгуулалт дутсан зэрэг асуудлуудаас шууд хамааралтай байгаагаас зарим шийдвэрүүдийн хэрэгжилтийн үр дүн хэрэгжих шатанд байна.

Тухайлбал: 2022 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр 54 дүгээр тэмдэглэл “Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн систем”-ийг байгууллагын үйл ажиллагаанд уялдуулан зохион байгуулах агентлагуудын зөрчил шалгадаг эрх бүхий албан хаагчдыг хооронд нь программаар холбох талаар удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах, төсөв санхүүгийн асуудлыг шийдвэрлэж, төсөвт тусгуулж батлуулах шаардлагатай байна.

2022 оны жилийн эцсийн байдлаар хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хяналтад авсан заалтууд 96.9 хувийн биелэлттэй байгаа нь өмнөх жилүүдтэй харьцуулахад буурсан үзүүлэлттэй байгааг доорх графикаар үзүүлэв.



График үзүүлэлтийн 2020, 2021 оны үнэлгээний дундажтай харьцуулахад 2022 онд өссөн үзүүлэлттэй байгаа нь Тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 2 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлэх, цахим шилжилтийн арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлж, “Иргэдэд үйлчлэх нэгдсэн төв”-тэй болох асуудалд ач холбогдол өгч шаардагдах төсвийг батлуулан, ашиглалтад оруулж үйл ажиллагаа нь жигдэрсэн. Мөн хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2022 оны эхний хагас жилийн биелэлтийг тооцож, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заагдсан 22 заалтын биелэлтийг эрчимжүүлэх талаар аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, цаашид авч хэрэгжүүлэх зохион байгуулалтын ажлын талаар шийдвэр гаргуулсны үндсэн дээр биелэлт нэлээдгүй хувиар ахисан байна.

Үнэлгээгээр гарсан үр дүн, хэрэгжилт удаашралтай шийдвэрүүдийн зүйл, заалт нэг бүрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах талаар сум, байгууллагуудад чиглэл өгч ажиллалаа.

Дүгнэлт:

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийн явцад хагас, бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хэрэгжилт удааширсан, эрчимжүүлэх шаардлагатай ажлуудыг илрүүлэн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн дүгнэлт, зөвлөмжийн дагуу гүйцэтгэлийг сайжруулан ажилласнаар тайлангийн чанар сайжирсан эерэг үр дүн гарч байна.

2022 оны жилийн эцсийн хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтээс зохион байгуулалтын хувьд аймгаас шалтгаалах зүйлгүй, хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрээс үүдэн хэрэгжих боломжгүй хэд хэдэн шийдвэрүүдэд хасуулах санал өгч,

хяналтаас хасуулсан ба нэг удаагийн буюу зохион байгуулалтын чанартай шийдвэрийн биелэлтүүд хангагдсан нь 2020, 2021 оны жилийн эцсийн тайлангийн харьцуулсан үзүүлэлтээс харагдаж байна.

2022 оны жилийн эцсийн байдлаар аймагт даалгасан 42 шийдвэрийн 125 заалтын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн Засгийн газрын “Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан”-д хугацаанд нь байршуулж, тайланг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 03/101 дугаар албан бичгээр хүргүүлээ.

Нэгдсэн зөвлөмж:

Тогтоол шийдвэрийн хэрэгжилт 96.9 хувьтай байгаа хэдий ч агентлаг, сум, байгууллагын удирдлагууд шийдвэрийн хэрэгжилтийг мэдээлэх, тайлагнахад үйл ажиллагааг дурдсан, тооцоо судалгаа байхгүй, гарсан үр дүнг мэдээлэхгүй, хувийг хэт өсгөх зэрэг зөрчил дутагдал байгаад анхаарах;

Тайланг хэтэрхий нуршсан, үр дүнг бус үйл ажиллагааг тоочон тайлагнасан тохиолдлууд давтагдсаар байгаа тул тайланг график, хүснэгт ашиглаж, тухайн шийдвэрийг хэрэгжүүлснээр гарсан гол үр дүнг товч тодорхой тайлагнах;

Хариуцсан салбарын тогтоол шийдвэрийн биелэлтийг харьяа газар, хэлтсүүдээс нэгтгэн авахдаа тухайн тайланд дүн шинжилгээ, боловсруулалт хийсний үндсэн дээр, хэлтсийн даргад танилцуулж, хэлтсийн даргын гарын үсгээр баталгаажуулан, эцсийн тайланд өгөх;

Аймгийн Засаг даргын 2021 оны А/207 дугаар захирамжаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын 8-р зүйлийн 8.7 дахь заалт Захиргааны байгууллага бодит шалтгааны улмаас хэрэгжих боломжгүй, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон сүүлийн 3 жил тасарсан болон тухайн асуудлаар дахин шийдвэр гарсан, хэрэгжилт тогтмолжсон шийдвэрүүдийг дотооддоо хяналтад авч хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн заалтыг хүчингүй болгох, хяналтаас хасах тухай саналыг жилийн эцсийн тайлангийн хамт хүргүүлэхэд анхаарч ажиллах. Тус журмын дагуу тайлагналтыг сайжруулж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах шаардлагатай. Тухайлбал: Нэг ажлыг хэд хэдэн заалтын биелэлтэд тайлагнах, тухайн заалтад хамааралгүй биелэлт гаргах, хэт нурших, зэрэг нийтлэг алдаа дутагдлыг дараа дараагийн тайланд засаж сайжруулан, үйл ажиллагаандаа анхаарч, хариуцлагатай тайлагнахыг хариуцсан салбарын газар, хэлтсүүдэд анхааруулж байна.

ТАЙЛАН БИЧСЭН: ХШҮХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН

Б.НАСАНЖАРГАЛ

ТАНИЛЦСАН: АЗДТГ-ЫН ДАРГА

Д.АЛТАНШАГАЙ